



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 16 сарын 06 өдөр

Дугаар 1/41

Амардалай

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага  
худалдаа явуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, сумын 2022 оны "Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө"-г үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Дэлгэрцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 07-р хуралдааны 04 дугаар тогтоолын дагуу Дэлгэрцогт сумын нутаг дэвсгэр Хаданхошуунд байршилтай 2622 м.кв (0.2 га) газрыг гэр орон сууцны хашааны газрын зориулалтаар газар эзэмших эрхийн дуудлага худалдааг цахимаар дахин зохион байгуулсугай.

2. Дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэх газрын хэмжээ, зориулалт байршил, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дуудлага худалдаа явуулах өдрийг хавсралтаар баталсугай.

3. Дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулж, дуудлага худалдааны зар мэдээг [www.mle.mn](http://www.mle.mn) газрын цахим биржид болон мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй зарлан явуулсугай.

4. Дуудлага худалдаа явуулах хугацаа, тавигдах шаардлага нөхцлүүдийг тодорхойлон олон нийтэд зарлан мэдэгдэж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн  
А/41 дугаар захирамжийн хавсралт

| Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газар |                                   |                                             |                             |             |           |                |                    |                               |                                |                                  |
|----------------------------------------|-----------------------------------|---------------------------------------------|-----------------------------|-------------|-----------|----------------|--------------------|-------------------------------|--------------------------------|----------------------------------|
| №                                      | Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар | Газрын хаяг                                 | Газрын зориулалт            | Хэмжээ м.кв | Анхны үнэ | Дэнчингийн үнэ | Эзэмшүүлэх хугацаа | Дуудлага                      | Дуудлага                       | Дуудлага худалдаа явуулах хэлбэр |
|                                        |                                   |                                             |                             |             |           |                |                    | худалдаа зарлаж эхлэх хугацаа | худалдаа явагдаж эхлэх хугацаа |                                  |
| 0                                      | 1                                 | 2                                           | 3                           | 6           | 8         | 9              | 10                 | 11                            | 12                             | 13                               |
| 1                                      | 2532570                           | 3-р баг Хадан хошуу, засмал замын зүүн талд | Гэр орон сууц хашааны газар | 2622        | 1,468,320 | 146,830        | 15                 | 2022.06.06                    | 2022.06.20                     | Цахим                            |